



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 497

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.2.4, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын ашиглалтын хуг хугацаа дууссан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн мөн цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон 12 нэрийн, нийт 43,580,339.99 (дөчин гурван сая таван зуун наян мянга гурван зуун гучин есөн төгрөг ерэн есөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 41,718,641.12 (дөчин нэгэн сая долоон зуун арван найман мянга зургаан зуун дөчин нэгэн төгрөг арван хоёр) хуримтлагдсан элэгдэл 1.2бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Дуламсүрэн, Ой судалгаа хөгжлийн төвийн дарга Д.Мөнхбат, Алтайн өвөр говийн сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Мөнхзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГӨЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
497 дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬАА БАЙГУУЛЛАГУУДЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад /бүртгэлд/ орсон он	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгөр)	Балансын үнэ (төгөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгөр)	Үлдэгдэл өртөг (төгөр)
1.Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа							
1	Мотоцикл /Li Fan/	2014	7	1,698,000.00	11,886,000.00	11,886,000.00	-
2	Мотоцикл /Shinera/	2015	2	1,790,250.00	3,580,500.00	3,580,500.00	-
3	Усан фонтан	2015	1	9,444,045.43	9,444,045.43	9,444,045.43	-
4	Явган зам	2014	1	5969817.22	5,969,817.22	5,969,817.22	-
5	Гар аргаар модны нүх ухагч өрөм	2013	1	666,667.00	666,667.00	666,667.00	-
6	Түлшний сав	2017	1	38,500.00	38,500.00	38,500.00	-
7	Ойн гап унтраах үүргэвч RLO- 6M	2017	5	412,000.00	2,060,000.00	2,060,000.00	-
8	Мод	2018	10	7,450.00	74,500.00	74,500.00	-
	Дүн	-	28		33,720,029.65	33,720,029.65	
2.Ойн судалгаа хөгжлийн төв							
9	Трактор ХТ32511Д120 68-32	2005	1	3,438,278	3,438,278.19	3,438,278.19	-
10	Трактор ХТ32511Д120 68-33	2005	1	3,438,278	3,438,278.19	3,438,278.19	-
	Дүн	-	2		6,876,556.38	6,876,556.38	

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
3. Алтайн өвөр говийн сав газрын захиргаа							
11	Мотоцикл /li fan/	2014	1	1,698,000.00	1,698,000.00	626,805.09	1,071,194.91
12	Нарны толь	2015	1	1,285,753.96	1,285,753.96	495,250.00	790,503.96
	Дүн		11		2,983,753.96	1,122,055.09	1,861,698.87
			39		43,580,339.99	41,718,641.12	1,861,698.87
	НИЙТ ДҮН				(дөчин гурван сая таван зуун наян мянга гурван зуун гучин есөн төгрөг ерэн есөн мөнгө)	(дөчин нэгэн сая долоон зуун арван найман мянга зургаан зуун дөчин нэгэн төгрөг арван хоёр мөнгө)	(нэг сая найман зуун жаран нэгэн мянга зургаан зуун ерэн найман төгрөг наян долоон мөнгө)